

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/321/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Энхтуяа Утас: 261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn Аудитор: Н.Нямсүрэн Утас: 261628 Цахим хаяг: nyamsurenn@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРАЛ
А.БУЯННЭМЭХ ТАНАА

2024.02.23 № 04/295

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 8,436.2 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлах 4000 м.кв газар дээр Бүгд найрамдах Солонгос улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА), Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам хамтран Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг сайжруулах төсөл хэрэгжүүлж байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 24, нийт 25 ажилтантай батлагдсан өрөн тооны хязгаарт багтааж, ажилласан байна. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн УТҮГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төсвийн Зам, тээврийн хөгжлийн яаманд хянуулж, төсвийн шууд захирагч баталсан. Нийт 38 арга хэмжээг тусгаж хэрэгжүүлсэн бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын жилийн эцсийн үнэлгээгээр 87.1 хувиар дүгнэгдсэн байна.

Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангасан нэгдсэн удирдлага, зохицуулалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөж, хэрэгжүүлэх, удирдлагаар хангах ажлын хүрээнд хөдлөх бүрэлдэхүүний осол, сүйрэл, гологдлыг бүртгэж байна. 2023 онд галт тэргэнд тээврийн хэрэгсэл дайрагдсан 10, сум зүссэн 8, хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан 4, бэлэн бус замналаар галт тэрэг явуулсан 2, зорчигчийн галт тэрэгний зүтгүүр эвдэрсэн зэрэг нийт 65 удаагийн гологдол гарсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. W* Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,717,619.00	21,430,619.00
33	АВЛАГА	8,496,200.00	8,496,200.00
335	Бусад авлага	8,496,200.00	8,496,200.00
3351	Байгууллагаас авах авлага	8,496,200.00	8,496,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,221,419.00	12,934,419.00
351	Түүхий эд материал	10,045,487.00	10,045,487.00
35110	Тусгай зориулалттай материал	10,045,487.00	10,045,487.00
354	Хангамжийн материал	4,175,932.00	2,888,932.00
35410	Бичиг хэргийн материал	113,500.00	385,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,258,500.00	1,700,000.00
35470	Бусад хангамжийн материал	803,932.00	803,932.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,777,044,219.24	1,774,335,070.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,777,044,219.24	1,774,335,070.50
392	Биет хөрөнгө	3,059,219.24	350,070.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,338,000.00	57,338,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(57,338,000.00)	(57,338,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,531,490.00	43,531,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,217,505.40)	(43,531,490.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,974,857.18	26,974,857.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,229,622.54)	(26,624,786.68)
393	Биет бус хөрөнгө	1,773,985,000.00	1,773,985,000.00
39301	Программ хангамж	85,551,000.00	85,551,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(85,551,000.00)	(85,551,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,773,985,000.00	1,773,985,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,799,761,838.24	1,795,765,689.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	203,857.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	203,857.20
413	Өглөг	-	203,857.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		203,857.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,799,761,838.24	1,795,561,832.30
51	Засгийн газрын хувь оролцоо	1,799,761,838.24	1,795,561,832.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,615,360,000.00	1,615,360,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,615,360,000.00	1,615,360,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	184,401,838.24	180,201,832.30
51210	Өмнөх үеийн үр дүн	145,061,081.77	184,401,838.24
51220	Тайлант үеийн үр дүн	39,340,756.47	(4,200,005.94)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,799,761,838.24	1,795,765,689.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	724,106,336.89	782,346,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,807,436.89	-
120	Нийтлэг татварын бус орлого	93,807,436.89	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,985,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,985,000.00	-
120009	Бусад орлого	5,822,436.89	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	630,298,900.00	782,346,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	630,298,900.00	782,346,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	630,298,900.00	782,346,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	684,765,580.42	786,546,405.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,765,580.42	786,546,405.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,707,658.78	766,196,502.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,209,194.08	528,870,433.30
210101	Үндсэн цалин	298,215,023.43	304,373,328.71
210102	Нэмэгдэл	30,360,601.54	88,945,975.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,549,619.11	64,067,700.76
210104	Урамшуулал	10,083,950.00	71,483,428.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,004,766.00	66,355,557.20
210201	Тэтгэврийн даатгал	38,623,164.97	45,698,430.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,221,400.31	5,254,731.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,242,720.22	4,107,345.30
210204	Ажилгүйдлийн даатгал	810,679.80	1,026,986.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,106,800.70	10,268,063.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,312,190.00	80,892,000.00
210304	Байрны түрээс	97,312,190.00	80,892,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,970,656.98	24,106,516.82
210401	Бичиг хэрэг	17,393,800.00	8,382,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,844,300.00	5,458,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,386,628.98	7,932,972.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	171,900.00	2,332,844.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,410,600.00	-
210408	Бараа материал акталсны зардал	11,763,428.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,180,240.00	14,411,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	13,789,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,180,240.00	622,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,798,901.00	48,851,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,565,423.00	22,282,392.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,040,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,000.00	345,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,100.00	141,344.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,821,000.00	18,284,700.00
210807	Газрын төлбөр	78,500.00	3,600,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,763,878.00	1,697,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,231,710.72	2,709,148.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,805,600.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,426,110.72	2,709,148.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,057,921.64	20,349,903.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	17,380,460.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	800,000.00	796,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,584,260.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,257,921.64	2,969,443.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,257,921.64	2,969,443.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	39,340,756.47	(4,200,005.94)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	39,340,756.47	(4,200,005.94)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	636,121,336.89	782,346,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,822,436.89	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,822,436.89	-
120009	Бусад орлого	5,822,436.89	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	630,298,900.00	782,346,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	630,298,900.00	782,346,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	630,298,900.00	782,346,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	636,121,336.89	782,346,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636,121,336.89	782,346,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627,063,415.25	761,996,496.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,209,194.08	528,870,433.30
210101	Үндсэн цалин	298,215,023.43	304,373,328.71
210102	Нэмэгдэл	30,360,601.54	88,945,975.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,549,619.11	64,067,700.76
210104	Урамшуулал	10,083,950.00	71,483,428.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,270,061.19	66,151,700.00
210201	Тэтгэврийн даатгал	35,217,927.53	44,983,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,876,433.47	5,292,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,980,186.74	4,233,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	745,046.46	1,058,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,450,466.99	10,584,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,312,190.00	68,386,100.00
210304	Байрны түрээс	97,312,190.00	68,386,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,614,028.98	17,362,998.82
210401	Бичиг хэрэг	2,802,600.00	3,254,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,102,800.00	3,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,386,628.98	7,932,972.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,322,000.00	2,276,026.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,793,840.00	15,863,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,528,900.00	15,241,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,264,940.00	622,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,058,501.00	65,361,964.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,040,423.00	37,002,710.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,040,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,000.00	345,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,100.00	141,344.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,821,000.00	20,032,700.00
210807	Газрын төлбөр	78,500.00	3,600,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,548,478.00	1,739,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,805,600.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,805,600.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,057,921.64	20,349,903.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	17,380,460.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	800,000.00	796,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,584,260.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,257,921.64	2,969,443.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,257,921.64	2,969,443.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,615,360,000.00	140,326,376.96	1,755,686,376.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	4,734,704.81	4,734,704.81
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,615,360,000.00	145,061,081.77	1,760,421,081.77
C07	Тайлант үеийн үр дүн		39,340,756.47	39,340,756.47
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,615,360,000.00	184,401,838.24	1,799,761,838.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,615,360,000.00	184,401,838.24	1,799,761,838.24
D08	Тайлант үеийн үр дүн	-	(4,200,005.94)	(4,200,005.94)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,615,360,000.00	180,201,832.30	1,795,561,832.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	782,346,400.00	779,376,956.12	2,969,443.88	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	782,346,400.00	779,376,956.12	2,969,443.88	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	763,822,000.00	761,996,496.12	1,825,503.88	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	530,113,500.00	528,870,433.30	1,243,066.70	99.8
210101	Үндсэн цалин	349,508,600.00	304,373,328.71	45,135,271.29	87.1
210102	Нэмэгдэл	162,636,400.00	88,945,975.30	73,690,424.70	54.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,968,500.00	64,067,700.76	(46,099,200.76)	356.6
210104	Урамшуулал	-	71,483,428.53	(71,483,428.53)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,151,700.00	66,151,700.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	44,983,100.00	44,983,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,292,100.00	5,292,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,233,700.00	4,233,700.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,058,500.00	1,058,500.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,584,300.00	10,584,300.00	-	100.0
2103	Байр мандилтай холбоотой тогтмол зардал	68,438,500.00	68,386,100.00	52,400.00	99.9
210304	Байрны түрээс	68,438,500.00	68,386,100.00	52,400.00	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	17,624,700.00	17,362,998.82	261,701.18	98.5
210401	Бичиг хэрэг	2,751,200.00	3,254,000.00	(502,800.00)	118.3
210402	Тээвэр, шатахуун	5,001,800.00	3,900,000.00	1,101,800.00	78.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,262,200.00	7,932,972.82	329,227.18	96.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,609,500.00	2,276,026.00	(666,526.00)	141.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,864,200.00	15,863,300.00	900.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,242,100.00	15,241,200.00	900.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	622,100.00	622,100.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	32,500.00	-	32,500.00	-
210702	Дотоод албан томилолт	32,500.00	-	32,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,596,900.00	65,361,964.00	234,936.00	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,128,200.00	37,002,710.00	125,490.00	99.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	387,400.00	345,510.00	41,890.00	89.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,700.00	141,344.00	35,356.00	80.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,800.00	-	30,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,034,100.00	20,032,700.00	1,400.00	100.0
210807	Газрын төлбөр	3,600,000.00	3,600,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,739,700.00	1,739,700.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,524,400.00	17,380,460.00	1,143,940.00	93.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,524,400.00	17,380,460.00	1,143,940.00	93.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	796,200.00	796,200.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,728,200.00	16,584,260.00	1,143,940.00	93.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	782,346,400.00	779,376,956.12	2,969,443.88	99.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	782,346,400.00	779,376,956.12	2,969,443.88	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	782,346,400.00	779,376,956.12	2,969,443.88	99.6
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	24	24	-	100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг дутуу тайлагнасан алдаа¹ залрууллаа.

Аудитаар нийт 8,425.6 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 8,425.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг дутуу тайлагнасан	1	8,425.6	1	8,425.6	1
Дүн	1	8,425.6	1	8,425.6	1	8,425.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, программ хангамж зэрэг нийт 65 нэр төрлийн 169,189.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.	1	-			1	-
Тайлант онд 2,121 ширхэг хөдлөх бүрэлдэхүүнд тээврийн хэрэгслийн гэрчилгээг олгохдоо 5 ширхэг вагоны дунд 1 ширхэг гэрчилгээ олгосон байна.	1				1	-
Барьцаа хөрөнгийн 8,436.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	8,436.2	1	8,436.2		
Дүн	3	8,436.2	1	8,436.2	2	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Инкон ХХК-ийн хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээгүй, дугааргүй 2 вагоныг хөдөлгөөнд оруулан	1	-	1	-				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тээвэрлэлт хийлгэж, төмөр замын тээврийн аюулгүй байдал, стандартын шаардлага, технологийн горимыг зөрчсөн байна.								
Тус төвийн нэр дээр бүртгэлтэй орон сууц, конторын зориулалттай газар дээр зөвшөөрөлгүй орон сууцны барилга барих ажлыг эхлүүлж, эхний гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээг цуцалж, 2024 оны 01 дүгээр сард өөр компанитай гэрээг дахин байгуулсан боловч барилгын зөвшөөрөл аваагүй хэвээр байна.	1	-					1	-
Дүн	2	-	1	-	-	-	1	-
Нийт дүн	5	8,436.2	2	8,436.2	2	-	1	-